

БАТЛАВ:

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА

С.УРАНЦЭЦЭГ

2020 оны 02 дугаар сарын өдөр

**ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
“СУМЫН ТӨВИЙН КАМЕРЖУУЛАЛТ”-ЫН АЖИЛ
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт:

**“СУМЫН ТӨВИЙН КАМЕРЖУУЛАЛТ” АЖИЛ
Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах**

Төслийн дугаар:

ХА-2020/01

ҮНИЙН САНАЛЫН УРИЛГА

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Даланжаргалан сумын 4-р багт “Сумын төвийн камержуулалт” суурьлуулах ажилд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх бараа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийг **2020 оны 03-р сарын 10-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө** “tender.gov.mn” цахим хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03-р сарын 10-ны өдрийн, 11 цаг 30 минутад нээнэ.**

**Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ
tender.gov.mn**

Утас: 94582845, 94777007

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар
 - (г) Харилцагч банкны тодорхойлолт / өр төлбөргүй байх /
 - (д) Татварын газрын тодорхойлолт / өр төлбөргүй байх /

ж/ Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;

з/ Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт/ туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; /2017,2018 он /
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн буюу 2018, 2019 оны санхүүгийн тайлан, Чадварын мэдээлэл-туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, гэрээний хуулбар болон бусад баримт бичиг; /2018,2019 он /</p> <p>Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 2 жилд буюу 2018-2019 онуудад ижил төстэй ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байх/</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ - Гэрээг гүйцэтгэх удирдах ажилтны болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл - Машин механизм, тоног төхөөрөмжийн судалгаа
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Дорноговь аймаг Даланжаргалан сум 2020 он 03 сарын 10 өдөр</p> <p>Байгууллагын хаяг: Даланжаргалан сум 4-р баг Их сансар ЗДТГазар</p> <p>өрөөний дугаар: Даланжаргалан сумын ЗДТГ-ын Засаг даргын орлогчийн ажлын өрөө</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 10 -ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Даланжаргалан сумын ЗДТГазар, Засаг даргын орлогчийн ажлын өрөө</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 10-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 15.1	<p>Тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлэх</p>

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ТӨВИЙН КАМЕРЖУУЛАЛТ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Ерөнхий шаардлага:

Даланжаргалан сумын төвийн гудамж талбай, олон нийтийн газар, байгууллага, аж ахуй нэгжийн гадна болон дотор орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хөдөлгөөнт-10, чиглэлийн-6 нийт 16 ширхэг теле хяналтын камерыг суурьлуулна.

1. Теле хяналтын хэсэг: Хяналтын хэсэг нь бичлэг хадгалах төхөөрөмж, хяналтын дэлгэц, сүлжээний төхөөрөмж, цахилгаан тэжээлийн төхөөрөмж, холболт зэргээс бүрдэнэ.

1.1 Бичлэгийн төхөөрөмж нь камерын бичлэгийг 30 хоногоос доошгүй хугацаатай хадгалахаар багтаамжтайг сонгоно.

1.2 Хяналтын дэлгэцтэй байна.

1.3 Тог тогтворжуулагчтай байна.

1.4 Төхөөрөмжийн хайрцагтай байх ба сүлжээ болон цахилгааны холболт, тог тогтворжуулагч тэжээлийн адаптерууд багтаахад сонгоно.

2. Теле хяналтын цэг:

2.1 Төхөөрөмжийн хайрцаг нь тухайн цэгийн тоног төхөөрөмжүүдийг /хүчдэл тогтворжуулагч-1ш, утасгүй сүлжээний антен болон камерын тэжээлийн адаптер, цахилгааны холболт монтаж гэх мэт бусад холболтууд/ багтаах зайтай байна.

2.2 Тоос, шороо, ус чийгний хамгаалалттай зориулалтын хайрцаг байна.

2.3 Утасгүй сүлжээний антен нь гадна ажиллах зориулалтын хайрцаг байна.

2.4 Хяналтын камерыг гэрэлтүүлэгтэй орчинд байрлуулах ба харагдах талбай хязгаарлагдахгүй байхаар байрлуулна.

3. Дэд бүтэц:

3.1 Хяналтын цэгийг байнгын цахилгааны тэжээлтэй, найдвартай эх үүсвэрээс стандартын дагуу холбоно.

3.2 Хяналтын цэгүүдийг утасгүй сүлжээний антенаар хяналтын хэсэгт холбох ба хоорондын хамааралгүй байхаар холболт тохируулгыг хийнэ. Хяналтын хэсэг 2 байна.

3.3 Цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгчийн байранд сүлжээг нэгтгэнэ.

4. Бусад:

4.1 Баталгаат хугацаанд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн гэмтлийг бүрэн хариуцна.

4.2 Нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг захиалагчийн байранд суурьлуулж 72 цаг тасралтгүй ажиллуулан шалгасны дараа хүлээлгэж өгнө.

4.3 Сууриллагдах тоног төхөөрөмж нь 220В, 50Гц+5% хүчдэлд ажилладаг байхаар сонгоно.

4.4 Төхөөрөмжүүд нь 7/24/365 өдөр байнгын тасралтгүй ажиллах чадвартай байхаар сонгоно.

4.5 Олон улсын чанарын шаардлага хангасан тоног төхөөрөмжүүд байна.

4.6 Теле-хяналтын камерын цэгт суурилуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт, сүлжээний болон цахилгааны холболтын ажлын зургийг гаргаж захиалагч талд хүлээлгэн өгнө.

4.7 Захиалагч болон гүйцэтгэгч талууд тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэгч нь камерийг сумын төвийг хянах боломжтой цэгүүдэд суурилуулна.

Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Нэр	Тоо ширхэг
1	Ubiquiti rocket m5	1ш
2	Air max Omni antenna 360 5ghz	1ш
3	Ubiquiti power beam 5ghz	16ш
4	Power supply 12v30a	3ш
5	Power supply 12v 2a	15ш
6	UTP cat6e	300m
7	Ip camera 360 outdoor	10ш
8	Ip camera 90' outdoor	6 ш
9	Display 43 inch	1ш
	Display 56 inch	1 ш
10	NVR 32 channel	1ш
11	HDD 8 tb	3ш
12	RJ45	1x
13	Суурь	4ш
14	Power cable	200m
15	PDU	5ш
16	Rack 22u	1ш
17	Connecter jam	4ш
18	PVC	200m
19	Network tester	1ш
20	Scratch	4ш
21	Switch 16port	1
22	БҮГД	

№	Техникийн үзүүлэлт
1	<p>NVR бичигч</p> <ul style="list-style-type: none"> • 32 сувгийн with 1080p Нягтаршлаар харах • H.264/MJPEG Бичлэгийн Формат • Max 4Ch.@1080p, 720p, D1 Бичих төрөл
	<ul style="list-style-type: none"> • Дараах зүйлсийг дэмждэг байх 4 SATA HDDs up to 16 TB, 1 eSATA up to 16TB, 4 USB2.0 • HDMI / VGA Видео гаралтын интерфейс буюу холболт • Аль ч төрлийн брэндийн сүлжээний камерыг дэмжин ажиллах боломжтой байх • ONVIF Version 2.0 conformance -Урсгалын протокол нь Онвип 2.0с дээш • Mobile Software: Утасны программ хангамж буюу аппликейшн дэмждэг байх /Cloud system- Үүлэн тооцооллын технологи дэмждэг байх/
2	<p>Camera /Камерын үзүүлэлт/</p> <ul style="list-style-type: none"> • Ports: (1) 10/100 Ethernet - /Сүлжээний порт фаст этэрнэт 1ш 10/100/ • Sensor: Progressive Scan RGB CMOSJ" - /Мэдрэгч: Өнгөт / • Lens: 4.0mm/ F1.5- /4мм зүүм хийдэг байх/ • Horizontal of View: 90°- /харах өнцөг 90 градус болон 360 градус/ • Ethernet Ports: Auto MDIX, autosensing 10/100 Mbps /Сүлжээний хурд 10/100 мега • Power LED: Red- /Асах гэрэл Улаан/ • Link/Active LED: Green- /Холболтын идэвхитэй байхыг Ногоон гэрэлээр харна/ • Maximum Power Consumption: 2.4 Watts- /тэжээлийн чадал -2.4Ватт/ <p>Video -Видео</p> <ul style="list-style-type: none"> • Video Compression: H.264/MPEG-4/MJPEG -Видео шахалт Эйч.264/ЭмПиАйЖ-4 • Resolution: 4MP/HDTV 720p-Нягтаршил 4мегапиксел, 720p • Maximum Frame Rate: 30 FPS - Хамгийн ихдээ секундэнд 30 фрэйм дамжуулах • Image Setting: Brightness, Contrast, Sharpness, Saturation, 50Hz/60Hz - Зургийн тохиргоо: цайруулах, Өнгө нэмэх, Тод, Нэг цэгт төвлөрөх хүч 50-60герц-ээс дээш <p>General - Ерөнхий үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Processor: ARM-based 32-bit RISC -процессер 32битийн тооцоолол хийх • Memory: 128MB DDR2 SDRAM, 8MB Flash- Санах ой: 128м рам флаш 8мб • Connector: RJ-45 10BASE-T/100BASE-TX PoE- Холболт РЖ-45, этэрнэт тэжээл • Maximum Active Array Size: 1280x800- Идэвхитэй цэгийн хэмжээ 1280*800 • View Angle: 47° (H), 31° (V), 54° (D) 360° Харах өнцөг тохируулах 47" 31" 54" 360" <p>Network Камерын сүлжээний үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Security: Multiple user access levels with password protection, User access log • Нууцлал: Олон хэрэглэгчийг түвшин бүрээр нэвтрэх нэр болон нууц үг тохируулах боломжтой • Supported Protocols: IPv4/v6, HTTP, UPnP, DNS, NTP, RTSP, DHCP, TCP, UDP, IGMP, RTCP, ICMP, ARP • Дэмжих протоколууд IPv4/v6, HTTP, UPnP, DNS, NTP, RTSP, DHCP, TCP, UDP, Power-Тэжээл • Power Method: Passive Power over Ethernet (12-24V)-Тогтмол тэжээл 12-24вольт • Power Supply: 24V/0.5A PoE Adapter included

	<p>Physical Физик бүтэц</p> <ul style="list-style-type: none"> • Dimensions: 158 x 61.5 x 58.5 mm (without mounting arm), 264 x 61.5 x 58.5 mm (with mounting arm)- Хэмжүүрүүд 158*61.5*58.5 • Weight: 240 g (196 g without mounting arm) Жин 240гр • Mounting: Wall/Ceiling Adapter Kit included - Хананд суурьлуулах <p>Environmental- Байгаль цаг уурын үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Operating Temperature: Температур -40 to 70° C (-40 to 158° F) Целсийн -40 +70, Фарангейт -40 158 • Operating Humidity: 20 - 80% Noncondensing- харьцангуй чийгшил 20-80% 																		
3	<p>Wireless antenna.- Утасгүй сүлжээний антенъ Processor Specs Atheros:- Процесср MIPS 24KC, 400MHz</p> <p>Memory Information:/Санах ойн үзүүлэлт/ 64MB SDRAM, 8MB Flash Networking Interface:/Сүлжээний интерфэйс/ 1 X 10/100 BASE-TX (Cat. 5, RJ-45) Ethernet Interface Enclosure Size: /Хэмжээ/ 16cm length x 8cm width x 3cm height Weight: /Жин/ 0.5 kg RF Connector: /Радио холболт/ 2x RPSMA (Waterproof) Enclosure Characteristics: Outdoor UV Stabalized Plastic -Гадна зориулагдсан хуванцар материалтай</p> <p>Max Power Consumption:/Тэжээлийн чадал дундаж/ 8 Watts Power Supply:/Тэжээлийн холболт/ 24V, 1A POE Supply Included Power Method: Passive Power over Ethernet (pairs 4,5+; 7,8 return) Operating Temperature:/орчны температур/ -30C to 75C Operating Humidity:/Харьцангуй чийгшил/ 5 to 95% Condensing</p>																		
	<p>360 antenna: 360градусын антенъ</p> <table border="1" data-bbox="268 1435 1337 1841"> <tr> <td>Model загвар</td> <td>АМО-2G10</td> </tr> <tr> <td>Dimensions (mm)</td> <td>Хэмжээ 1030 X 122 X 84</td> </tr> <tr> <td>Weight Жин</td> <td>2.1 kg</td> </tr> <tr> <td>Frequency Range</td> <td>Радио давтамж 2.35 - 2.55 GHz</td> </tr> <tr> <td>Gain</td> <td>Антенъ өсгөлт 10 dBi</td> </tr> <tr> <td>Elevation Beamwidth</td> <td>12°</td> </tr> <tr> <td>Max VSWR</td> <td>1.7:1</td> </tr> <tr> <td>Downtilt</td> <td>4°</td> </tr> <tr> <td>Wind Survivability</td> <td>125 mph</td> </tr> </table>	Model загвар	АМО-2G10	Dimensions (mm)	Хэмжээ 1030 X 122 X 84	Weight Жин	2.1 kg	Frequency Range	Радио давтамж 2.35 - 2.55 GHz	Gain	Антенъ өсгөлт 10 dBi	Elevation Beamwidth	12°	Max VSWR	1.7:1	Downtilt	4°	Wind Survivability	125 mph
Model загвар	АМО-2G10																		
Dimensions (mm)	Хэмжээ 1030 X 122 X 84																		
Weight Жин	2.1 kg																		
Frequency Range	Радио давтамж 2.35 - 2.55 GHz																		
Gain	Антенъ өсгөлт 10 dBi																		
Elevation Beamwidth	12°																		
Max VSWR	1.7:1																		
Downtilt	4°																		
Wind Survivability	125 mph																		

	Wind Loading	14 lb @ 100 mph
	Polarization	Dual-Linear
	Cross-pol Isolation	25 dB min.
	ETSI Specification	EN 302 326 DN2
	Mounting	Universal Pole Mount, RocketM Bracket, and Weatherproof RF Jumpers Included
4	Switch- Сүлжээ салаалагч	
	Стандартууд	IEEE 802.3 10Base-T IEEE 802.3u 100Base-TX IEEE 802.3x Flow Control
	Сүлжээний орчин	Ethernet: UTP/STP Cat. 3, 4, 5 up to 100m Fast Ethernet: UTP/STP Cat. 5, 5e, 6 up to 100m
	Өгөгдлийн хурд	Ethernet: 10Mbps/20Mbps (half/full-duplex) Fast Ethernet: 100Mbps/200Mbps (half/full-duplex)
	Топологи	CSMA/CD, Star
	Тэжээлийн зарцуулалт	6watts (max)
	Свитч фабрик	3.2Gbps forwarding capacity
	Интерфейс	16 x 10/100Mbps Auto-MDIX RJ-45 ports
	Өгөгдлийн RAM буферийн хэмжээ	1.25Mbits
	Шүүлтүүр хийх хаягийн хүснэгт	8K MAC entries
	Үзүүлэлтийн LED гэрэл	Power, Link/ACT, Speed
	Тэжээлийн адаптер	7.5V DC, 1A external power adapter
	Хэмжээ	440 x 140 x 44mm (17.3 x 5.5 x 1.7in.)
	Жин	1.72kg (3.8lb)
	Температур	Operating: 0° ~ 50° C (32° ~ 122° F) Storage: -10° ~ 70° C (14° ~ 158° F)
	Чийгшил	Operating: 10% ~ 90% (non-condensing) Storage: 5% ~ 90% (non-condensing)
	Сертификат	CE, FCC
5	Wireless antenna with camera WLAN:Ubiquiti PowerBeam PBE-5AC-400-ISO,5GHz,25dBi,450+ Mbps,25+ km,w/ISO	
6	Rack 4 сэнстэй, 1 тавцантай, шилэн хаалгатай.Өндөр: - 22unit Гүн : 1000мм буюу 100см Урт : 600мм буюу 60см	
7	Cable FTP Cable:APCE Cat.6,4pair 0.55mm Copper,Double jacket PVC+ PE,Tross,(LACU5013M)	

8

Display- Дэлгэц

Inch 43 дээш

Нягтрал 1920*1080

Дүрс дамжуулах хурд 60ghz

Дууны эфэкт 2*7w

Холболтууд HDMI, USB, DVI, энгийн

Нягтрал 3000:1

ЗАРИМ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ТОДОТГОСОН ТОДОРХОЙЛОЛТ

№	Материалын нэр	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Гадаа зориулалтын чиглэлийн камер	<ul style="list-style-type: none"> • Тоон технологи дээр суурилсан байна. • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • Ус чийг, шороо тоос, доргилт, чичиргээнээс хамгаалагдсан олон улсын IP66, IP67 болон түүнээс дээш стандартыг хангасан байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPv4/v6 HTTP, HTTPS, QoS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • SMPTE 274M стандартыг хангасан буюу 4MP-ээс доошгүй дүрсний нягтралтай байна. • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.265, Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption гэх мэт хамгаалалттай байна. • Хяналтын камер нь гудамж талбайд байгаа олон нийтийн хөдөлгөөнийг бүхэлд нь харах боломжтой буюу 3.6mm-96mm байна. • Орчны гэрэлд тохирч ажиллах, автомат функцтэй байна. • Хамгийн бага гэрлийн орчин нь хар цагаан горимд 0.05 люкс эсвэл, өнгөт горимд 0,1люкс эсвэл түүнээс доош байна. 	6 ш
2	Гадаа зориулалтын хөдөлгөөнт камер PTZ 360	<p>Тоон технологи дээр суурилсан байна.</p> <p>360 градус эргэдэг 30xZoom татах</p> <ul style="list-style-type: none"> • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • Ус чийг, шороо тоос, доргилт, чичиргээнээс хамгаалагдсан олон улсын IP66 болон түүнээс дээш стандартыг хангасан байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPv4/v6 HTTP, HTTPS, QoS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • SMPTE 274M стандартыг хангасан буюу 5MP-ээс доошгүй дүрсний нягтралтай байна. • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.265, Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption гэх мэт хамгаалалттай байна. • Хяналтын камер нь өрөөнд байгаа олон нийтийн хөдөлгөөнийг бүхэлд нь харах боломжтой буюу 3.6mm- 96mm байна 	10 ш
4	Бичигч төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> • NVR, 8-32 port оролттой. • Digital zoom, audio video hdmivga output • Тоон технологи дээр суурилсан байна. • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPv4/v6 HTTP, HTTPS, QoS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.264/ H.265/ H.265+ Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS 	2 ш

		encryption гэх мэт хамгаалалттай байна.	
5	Хард диск	HDD 8000GB	1-2 ш
7	Battery	12v 20a	1ш
8	Антенн	Wifi Антенны үзүүлэлт: 10km range 5GHz to 433bps, 11AC IP64 усны хамгаалалттай 16dbi directional antenna AP, station, WISP etc operating mode supported up to 60 meters of flexible deployment included PoE injector	
9	Хяналтын дэлгэц	Сайн чанарын Өнгөт 43 inch-ын дэлгэц	2ш
10	Свич	Сүлжээний 4, 8, 16-н тус2 үүртэй байна	25ш
11	Тэжээлийн утас	Зэс голтой	500м
12	Тоолуур	220V электрон тоолуур (шаарлагатай байршилд байршуулах)	
13	Хар хоолой	Шаарлагатай байршилд байршуулах	
16	Сүлжээний толгой	Шаарлагатай байршилд байршуулах	
17	Цахилгааны самбар	Цахилгааны самбар	10
18	Камерын шон	Шинээр тавигдах байршилд 8 м өндөр шон 20-15 см-ын радиустай	8

- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл *[Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.]* гэж бичнэ
- 2. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн эрүүл ахуйн горимыг сахиж хайрцаг сав баглаа боодол эвдэрч хэмхэрээгүй байх.]
- 3. Бараа хүргэх газар:** [Барааг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГазар, бараа хүлээн авах комисст]
- 4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:** [Барааг гэрээнд заасан хугацаанд ирүүлж суурьлуулна]

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолт болон захиалагчийн шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/угас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг барааг хүлээн авч нэхэмжлэх хүлээн авснаас хойш шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

**11. Маргааныг
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Ажил, барааг хүлээн авахдаа нягтлан шалгаж хүлээн авна.

 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

 3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага. / 2жил /

 4. Төлбөр (ГЕН – 7)
 - 4.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 4 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.
 - 4.2 Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш ажлын 14 хоног байна.
 - 4.3. Захиалагчийн хяналтын зардлыг нийт гүйцэтгэлийн 2%-иар тооцно.
 - 4.3. Магадлашгүй ажлын зардал 2%

 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
 - 5.1 Алданги оногдуулах хувь: Хоногт **0.5** хувь
Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10** хувиас тус тус хэтрэхгүй
-

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг
- 5.3. Үнийн санал;
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 5.7. Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажил, барааг нийлүүлж, гэмтэл согог, доголдлыг арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, цахим болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]